ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/112/НА-СТА-ТШЗ**


Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Б.Авидцэрэн

Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт........................................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................
3. Аудитын тайлан ....................................................................................................................
3.1 Ерөнхий зүйл .....................................................................................................................
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........................................................................
3.4 Материаллаг байдал...........................................................................................................
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....................................................................................
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв......................................................................
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ...........................................................
3.8 Аудитын гол асуудал..........................................................................................................
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .........................
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .........................................................................................
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..............................................................................
4. Аудитын илрүүлэлт..............................................................................................................
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

## 1. Аудитын дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

БАЯНГОЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.УРТНАСАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 54667180.08 | 57044982.22 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 729499.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 729499.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 54667180.08 | 56315483.22 |
| 351 | Түүхий эд материал | 22598540.00 | 22562842.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22598540.00 | 22562842.00 |
| 354 | Хангамжийн материал | 32068640.08 | 33752641.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 166500.00 | 471000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4183246.00 | 8063924.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4179098.00 | 2320000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | |
| 35460 | Хүнсний материал | 10533196.00 | 5988082.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13006600.08 | 16909635.22 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 685024102.29 | 725542846.31 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 685024102.29 | 725542846.31 |
| 391 | Газар | | |
| 392 | Биет хөрөнгө | 674024102.29 | 714542846.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 695323241.90 | 723399241.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -37689555.69 | -52708421.54 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 32730246.00 | 42723966.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17517043.52 | -8796675.12 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9091030.59 | 8175752.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8504363.79 | -561666.48 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3873005.24 | 1549202.10 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3873005.24 | 0.00 |
| 39217 | Ном | 590546.80 | 761446.80 |
| 393 | Биет бус хөрөнгө | 11000000.00 | 11000000.00 |
| 39301 | Програм хангамж | 770000.00 | 770000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770000.00 | -770000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11000000.00 | 11000000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 739691282.37 | 782587828.53 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 739691282.37 | 782587828.53 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 739691282.37 | 782587828.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 122046522.00 | 122046522.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 122046522.00 | 122046522.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 4522857.71 | 47419403.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -61171749.29 | 4522857.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 65694607.00 | 42896546.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 613121902.66 | 613121902.66 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 739691282.37 | 782587828.53 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 367415730.00 | 361543063.75 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 71449000.00 | 47179770.75 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 71449000.00 | 47179770.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71449000.00 | 47179770.75 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 64663000.00 | 45138170.75 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6786000.00 | 2041600.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 295966730.00 | 314363293.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 259263430.00 | 282748700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 259263430.00 | 282748700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 6505000.00 | 747793.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6505000.00 | 747793.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 30198300.00 | 30866800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 30198300.00 | 30866800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 301406223.00 | 318646517.59 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 301406223.00 | 318646517.59 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 300826323.00 | 309464717.59 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 206778500.00 | 208950200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 131771987.00 | 143701320.00 |
| 210102 | Нэмэгдэл | 57329513.00 | 51391400.00 |
| 210104 | Урамшуулал | 17677000.00 | 13857480.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29314800.00 | 28865201.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20628900.00 | 20096401.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2171500.00 | 2192200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1737200.00 | 1753800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434300.00 | 438400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4342900.00 | 4384400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26567717.00 | 29907274.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1337607.00 | 1401076.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22611510.00 | 26959098.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2618600.00 | 1547100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6223827.30 | 5990408.86 |
| 210401 | Бичиг хэрэг | 664100.00 | 348200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1500000.00 | 1100000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1705600.00 | 1093600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 209300.00 | 141000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2144827.30 | 3307608.86 |
| 2105 | Нормативт зардал | 14923940.00 | 13587507.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69800.00 | 289593.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14349040.00 | 13297914.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 505100.00 | 0.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.00 | 1166200.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 1166200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 174400.00 | 174400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 174400.00 | 174400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 299900.00 | 299900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 299900.00 | 299900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16543238.70 | 20523626.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 219700.00 | 219700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 385600.00 | 693600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15937938.70 | 19610326.73 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 579900.00 | 9181800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 425000.00 | 219700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 425000.00 | 219700.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 154900.00 | 8962100.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 154900.00 | 8962100.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 66009507.00 | 42896546.16 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 314900.00 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 314900.00 | 0.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -314900.00 | 0.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 65694607.00 | 42896546.16 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 4,522,857.71 | 739,691,282.37 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 4,522,857.71 | 739,691,282.37 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 4,522,857.71 | 739,691,282.37 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 4,522,857.71 | 739,691,282.37 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 4,522,857.71 | 739,691,282.37 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 42,896,546.16 | 42,896,546.16 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 122,046,522.00 | 613,121,902.66 | 47,419,403.87 | 782,587,828.53 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 295966730.00 | 314363293.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 295966730.00 | 314363293.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 259263430.00 | 282748700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 259263430.00 | 282748700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 6505000.00 | 747793.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6505000.00 | 747793.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 30198300.00 | 30866800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 30198300.00 | 30866800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 289461730.00 | 299372393.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 289461730.00 | 299372393.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 288881830.00 | 290190593.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 206778500.00 | 208950200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 131771987.00 | 143701320.00 |
| 210102 | Нэмэгдэл | 57329513.00 | 51391400.00 |
| 210104 | Урамшуулал | 17677000.00 | 13857480.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29314800.00 | 29594700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20628900.00 | 20825900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2171500.00 | 2192200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1737200.00 | 1753800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434300.00 | 438400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4342900.00 | 4384400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28866400.00 | 28048176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1283702.00 | 1401076.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24964098.00 | 25100000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2618600.00 | 1547100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6208700.00 | 6839500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 244100.00 | 856100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1500000.00 | 1100000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1705600.00 | 1093600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 170900.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 209300.00 | 209300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2378800.00 | 3580500.00 |
| 2105 | Нормативт зардал | 14881930.00 | 10087193.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69800.00 | 817593.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13965030.00 | 8851100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 847100.00 | 418500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1331900.00 | 5318624.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 2500000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1331900.00 | 2818624.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 174400.00 | 174400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 174400.00 | 174400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 299900.00 | 299900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 299900.00 | 299900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1025300.00 | 877900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 219700.00 | 219700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 805600.00 | 658200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 579900.00 | 9181800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 425000.00 | 219700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 425000.00 | 219700.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 154900.00 | 8962100.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 154900.00 | 8962100.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 6505000.00 | 14990900.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 0.00 | 0.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 6505000.00 | 14990900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6505000.00 | 14990900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6505000.00 | 14990900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6505000.00 | 14990900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -6505000.00 | -14990900.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 304653400.00 | 304653400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 304653400.00 | 304653400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 304433700.00 | 304433700.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 208950200.00 | 208950200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 143701400.00 | 143701320.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51391400.00 | 51391400.00 |
| 210104 | Урамшуулал | 13857400.00 | 13857480.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29594700.00 | 29594700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20825900.00 | 20825900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2192200.00 | 2192200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1753800.00 | 1753800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 438400.00 | 438400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4384400.00 | 4384400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28048176.00 | 28048176.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1401076.00 | 1401076.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25100000.00 | 25100000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1547100.00 | 1547100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7730400.00 | 7730400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 244100.00 | 856100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1100000.00 | 1100000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1705600.00 | 1093600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 170900.00 | 170900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 209300.00 | 209300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4300500.00 | 4300500.00 |
| 2105 | Нормативт зардал | 9339400.00 | 9339400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69800.00 | 69800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8851100.00 | 8851100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 418500.00 | 418500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19418624.00 | 19418624.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16600000.00 | 16600000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2818624.00 | 2818624.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 174400.00 | 174400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 174400.00 | 174400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 299900.00 | 299900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 299900.00 | 299900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 877900.00 | 877900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 219700.00 | 219700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 658200.00 | 658200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 219700.00 | 219700.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 219700.00 | 219700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 219700.00 | 219700.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 304653400.00 | 304653400.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 273786600.00 | 273786600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 273786600.00 | 273786600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 30866800.00 | 30866800.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30866800.00 | 30866800.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 18.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1.00 | 1.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 1.00 | 1.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1.00 | 1.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 18.0 | 18.0 |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 18.00 | 18.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 747793.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 747793.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 747793.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 747793.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 747793.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 747793.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 747793.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 747793.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансух, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянгол сумын цэцэрлэг нь эрүүл, зөв монгол хүүхдийг хамтын хүчээр хөгжүүлж төлөвшүүлэх зорилготой, хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллага нь багийн төвийн цэцэрлэгээс анх удаа аймгийн тэргүүний цэцэрлэгээр шалгарсан ба байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрхлэгчийн тушаалаар батлагдсан дотоод хяналт, шалгалтын баг ажилладаг ба Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан журам, байгууллагын эрхлэгчийн баталсан журмыг мөрдөж, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 301.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 2.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 35.0 сая төгрөгөөр өссөн байгаа нь хөрөнгө оруулалтаар 28.1 сая төгрөгийн хөрөнгө орлогод авсан, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөнд дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэлд материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.
- Өглөгийн данс оны эцэст үлдэгдэлгүй байна.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийг авлагаар тайлагнажээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, сумын Санхүү, төрийн сангийн албанд нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 304.4 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 304.6 сая төгрөгөөр батлагджээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 304.6 сая төгрөгөөр батлагдаж, тодотголоор хянагдсанаар 295.6 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба оны нийт төсвийн гүйцэтгэл 295.6 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянгол сумын цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд 0.7 сая төгрөг ирсэн нь боловсролын байгууллагын ариутгал, халдваргүйтгэлд зориулж дээд шатны байгууллага болох аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас ирсэн бөгөөд зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйлээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс 2.0 сая төгрөгөөр тавилга эд хогшил, нормын хувцас худалдан авсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянгол сумын цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй нь санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг дээр онцолсон асуудлаас бусдаар холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт тавигдсаныг барагдуулж, 3 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлжээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилтнуудын цалин, нэмэгдэл урамшууллын тооцоололд анхаарал хандуулах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

### 4.3 Албан шаардлага

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс тавилга эд хогшил худалдан авсан зөрчилтэй холбогдуулж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж, тэвчиж болохуйц зардлыг хэмнэж ажиллах, төсөвт зардлын хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлж байх,

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянгол сумын цэцэрлэг | 1 | 2.1 | | | | | 1 | 2.1 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Б.АВИДЦЭРЭН